



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 3/1

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, Компаний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн “Баянхонгор-Эрчим хүч” ОНӨ ЦТХХК, “Цэвэр хөт” ОНӨ ХХК-уудыг хувьцаат компаний хэлбэрт шилжүүлэх дээрх компаниуд болон “Чандмань-Баянхонгор” ХК-ний ажиллагсад компаниас хувьцаа эзэмшүүлэх “Хувьцаа эзэмших хөтөлбөр”-ийг судлах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Энхтөр-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Гишүүд: Д.Ихбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Д.Уранчимэг: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Т.Бат-Очир-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Ж.Хүрэлбаатар-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Т.Отгонбаатар-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Э.Энхбат-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Б.Батбаяр-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Ж.Дулмаа-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Ч.Мөнхцэцэг-Орон нутгийн өмчийн харилцааны газрын дарга

2. Ажлын хэсгийн санал дүгнэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар 2016 оны 12 дугаар сарын 01-ний дотор хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Ц.Энхтөр/-д даалгасугай

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

116725



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 3/2

Номгон

"Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн  
корпораци" ХХК байгуулах тухай

Аймгийн 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3.ж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, Компаний тухай хуулийн 13 дугаар зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус III хуралдаанаас ТОГТООХ нь:


1. Аймгийн хөгжлийн хөтөлбөр, төслүүдийг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулж, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-ийг үүсгэн байгуулсугай.
2. "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-ний дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Компаний Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилохыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2016 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит  
бус III хуралдааны 3/2 дугаар тогтоолын хавсралт



**“БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ ХӨГЖЛИЙН  
КОРПОРАЦИ” ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙ ДҮРЭМ**

**Нэг: Нийтлэг үндэслэл**

1.1 “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК /цаашид “компани” гэх/ нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Компаний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгуулагдсан орон нутгийн өмчит компани мөн.

1.2 Монгол Улсын Компаний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрмээр компаний үйл ажиллагааг зохицуулах бөгөөд дүрэм нь: Компаний үйл ажиллагаа, засаглалын зарчим, зорилго, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам санхүүжилтийн эх үүсвэр, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх болон үйл ажиллагааны журмыг тодорхойлсон баримт бичиг болно.

**1.3 Компаний зорилго:**

Компани нь энэхүү дүрмийн хүрээнд аймгийн эдийн засгийн хөгжлийн стратеги, бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бизнесийн орчинг дэмжих замаар зах зээлийг өргөжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлж ажилгүйдэл ядуурлыг бууруулах.

**1.4 Хэрэгжүүлэх алхам:**

Баянхонгор аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор хувийн хэвшил болон гадаад, дотоодын хөрөнгийг төвлөрүүлэх, хөрөнгө босгох, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр төсвөөс олгосон санхүүжилт, хөгжлийн сан болон олон улсын төсөл зэрэг эх үүсвэрээс сан бүрдүүлж, төр хувийн хэвшилтэй хамтран бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлнэ.

**2. Компаний оноосон нэр, оршин байгаа газар**

2.1. Компани оноосон нэр “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци”

Компаний оршин байгаа газар /албан ёсны хаяг/ Баянхонгор сум

2.2. Компани нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, өөрийн бэлгэдэл /эмблем/ болон барааны тэмдэгтэй байна.

2.3. Компани нь ТУЗ-с баталсан албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг /тамга/, санхүүгийн тэмдгийг хэрэглэнэ.

### **3. Компаний үйл ажиллагааны чиглэл**

3.1. Компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

3.1.1. Баянхонгор аймгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн эдийн засгийн хөгжлийн стратегид тусгагдсан зарим төсөл, хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран санхүүжүүлэх, төр хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааны зохистой хэлбэрийг сонгох

3.1.2. ТУЗ-ийн зөвшөөрлөөр тодорхой төслийг санхүүжүүлэх зорилгоор төслийн зээл авах, хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах, төсвийн болон бусад эх үүсвэрээс хөрөнгө шилжүүлэн авах, олон улсын байгууллага, гадаад дотоодын хандивлагчдаас дэмжлэг туслалцаа авах зэргээр “Хөгжлийн сан” бүрдүүлэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

3.1.3. Баянхонгор аймгийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, аймгийн эдийн засгийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх чиглэлээр дараагийн санхүүгийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах төслийн талаар хувийн хэвшлээс гаргасан саналыг төлөвлөгөөнд тусгах, хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

3.1.4. Компаниас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд байгуулагдсан охин болон хараат компаний үйл ажиллагааг сайжруулах, зохистой хэлбэрээр өөрчлөн байгуулах, хэсэгчлэн болон бүрэн хувьчлах хөтөлбөрийн үндэслэл боловсруулан хувьчлалтай холбоотой асуудлыг ТУЗ-ийн хурлаар оруулж шийдвэрлүүлэх

3.1.5. Аймагт жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг гишүүнчлэлээр бүртгэн нэгдсэн бодлого удирдлага зохион байгуулагтаар хангаж ажиллах

3.1.6. Баянхонгор аймагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй хамтран “Нэг уурхай-нэг үйлдвэр” төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх. Хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулах

3.1.7. Улаанбаатар хот бусад төвлөрсөн суурин газар “Баянхонгорт үйлдвэрлэв” сүлжээ дэлгүүр байгуулах, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг тухайн дэлгүүрүүдээр зарж борлуулах сүлжээ үүсгэх

3.1.8. Тухайн жилийн шалгаруулалтаар брэнд бүтээгдэхүүнээр шалгарсан бараа бүтээгдэхүүний маркетинг, сурталчилгааг хийх хөрөнгө санхүүгийн эх үүсвэрээр дэмжих замаар зах зээлд гаргах

3.1.9. Жижиг дунд үйлдвэрлэлийн “Ажилсаг” төвийг хариуцан ажиллах

3.1.10 “Ажилсаг” төвөөр дамжуулан ирээдүйтэй ашиг олох ажлын байр нэмэгдүүлэх боломжтой жижиг дунд үйлдвэрийн төслийг бичих, иргэдийг сургах, зах зээлд гарахад нь дэмжлэг үзүүлэх

3.1.11 Жижиг дунд үйлдвэрийн бий болгоход шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газруудыг үйлдвэр эрхлэгчдэд эзэмшүүлэх, ашиглуулах талаар холбогдох байгууллага албан тушаалтад саналаа хүргүүлэх

3.1.12 Аймгийн жижиг дунд үйлдвэр хүний нөөц, бараа бүтээгдэхүүний зах зээлийн судалгааг гаргах, бодлого гаргагчдын мэдээллээр хангах саналаа хүргүүлэх

3.1.13 Шинэ бүтээл оновчтой санал, Тэргүүн туршлагыг хөгжүүлэх үйлдвэрлэлд нэвтрүүлэх

3.1.14 Хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, ХАА-с орох боломжит орлогыг нэмэгдүүлэх

3.2 Компани нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

3.3. Компаний зохион байгуулалт хэрэгжүүлж буй төслийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь олон улсын болон дотоодын стандартад нийцсэн байх шаардлагыг хангаж ажиллана.

#### **4. Компаний эрх**

4.1. Компани нь Монгол Улсын Компаний тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, гадаад, дотоодын банкинд төгрөгийн болон валютын данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, түүнийг захиран зарцуулах эрх нь хуулиар тодорхойлогдсон бие даасан хуулийн этгээд мөн.

4.2. Компани нь өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллага, аж ахуй нэгжтэй гэрээ, хэлцэл байгуулах, гэрээ хэлэлцээрт гуравдагч этгээдээр оролцох, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх олж авах, үүрэг хүлээх, шүүх, арбитрын үйл ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч нар оролцох эрхтэй.

4.3. Компани нь монгол улсын нутаг дэвсгэр болон гадаадад өөрийн төлөөлөгчийн газраа байгуулж болно.

4.4. Компани нь өөрийн “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК гэсэн нэрийг бүхий л үйл ажиллагаандаа ашиглана.

#### **5. Төлөөлөн удирдах зөвлөл**

5.1 Компаний төлөөлөн удирдах зөвлөлийг 9 гишүүнтэйгээр 3 жилийн хугацаатай сонгох бөгөөд тэдгээрийн 1/3 нь аймгийн төлөөлөл, 1/3 хувийн хэвшлийн төлөөлөл, 1/3 нь хараат бус гишүүд байна. Аймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн албан хаагчдын төлөөллийн бүрэлдэхүүнд байна.

5.2 ТУЗ-ийн гишүүнийг улиуулан сонгож болно. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх журам, эдний үйл ажиллагаа болон ёс зүйн дүрэм, ТУЗ-ийн хуралд бэлтгэх, зохион байгуулж явуулах, ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ өгөх болон дүгнэлт өгөх журм, ТУЗ-ийн даргын болон нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компаний тухай хууль, Монголын компаний засаглалын кодексийн зарчимд нийцсэн "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-аар тогтооно.

5.3 Компаний ТУЗ нь Компаний тухай хуульд заасан болон дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

5.3.1 Баянхонгор аймгийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, аймгийн эдийн засгийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аас баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан өөрт хуваарилагдсан төсөл, хөтөлбөрийг хувийн хэвшлийн оролцостойгоор хэрэгжүүлэх.

5.3.2 Төслийг санхүүжүүлэх эр үүсвэрийн талаар шийдвэр гаргах /хөгжлийн сангийн үлдэгдэл хөрөнгө хүрэлцэхгүй нөхцөлд зээл авах, хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах г.м/

5.3.3 Компаний гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин урамшууллыг тогтоох.

5.3.4 ТУЗ-ийн дотоод аудитын болон хөндлөнгийн аудитын байгууллагатай гэрээ байгуулах шийдвэр гаргах.

5.3.5 Хуримтлагдсан ашгийн хэмжээ, түүгээр хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөг хэлэлцэх

5.3.6 Компаний салбар болон төлөөлөгчийн газар байгуулах, үйл ажиллагааны журмыг баталж захирлыг томилох

5.3.7 Компаний жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт өөрийн үйл ажиллагааны болон үнэлгээний тайланг батлах

5.3.8 Хувийн хэвшилтэй хамтран ажиллах, ТУЗ-д хувийн хэвшлийн төлөөлөл сонгон оруулах төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулагч, гэрээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хамтран ажиллах зарчмыг тусгасан санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах шийдвэр гаргах

5.3.9. Гүйцэтгэх удирдлагын саналаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал

5.3.10. Компаний тухай хуульд заасан бусад асуудлууд

5.4. ТУЗ-ийн гишүүд нь энэ дүрмээр тогтоосон компаний зорилгыг хэрэгжүүлэх аймгийн хөгжил цэцэглэлтийн төлөө ажиллах үүрэгтэй. Энэ дүрэм болон компаний ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтоосон үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, ТУЗ-с гаргаж буй шийдвэрт сонирхогч этгээд гэдгээ мэдэгдэлгүйгээр энэ дүрэм журмыг зөрчсөн ТУЗ-ийн гишүүнийг ТУЗ-ийн хурлаар хэдийд ч үүрэгт ажлаас нь чөлөөлөх эрхтэй.

5.5. ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд нэг удаа хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд нэмэлт хуралдаан хийж болно.

5.6. ТУЗ-ийн гишүүдийн хуралд оролцох болон нарийн бичгийн даргын ажил үүрэгтэй холбогдон гарах зардлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны төсөвт оруулан тооцсон байна.

5.7. ТУЗ-ийн гишүүдийн 2/3 оролцооноор хурал хүчин төгөлдөр болно. Хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд утас буюу онлайнаар хуралд оролцож болно.

5.8. ТУЗ-ийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд саналын 1 эрхтэй оролцох бөгөөд гишүүдийн 2/3 буюу түүнээс дээшхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд ТУЗ-ийн даргын санал шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

5.9. Компаний гүйцэтгэх захирлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг аймгийн Засаг даргад уламжлан батламжлуулах саналыг хүргүүлэх.

## **6. Гүйцэтгэх удирдлага**

6.1. Компаний өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-с санал болгож, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан гүйцэтгэх захирал удирдана.

6.2. Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний хугацаа доод тал нь 5 жил байх бөгөөд гэрээг хэдэн ч удаа сунгаж болно. Энэхүү гэрээнд гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, эрх үүргийг тогтоосон байна.

6.3. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, энэ дүрэм болон гэрээгээр тогтоосон бүрэн эрхээ хэтрүүлсэн гэж ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх нь (2/3) үзвэл гэрээг цуцлах тухай шийдвэрийг ТУЗ хэдийд ч гаргах эрхтэй.

6.4. Гүйцэтгэх захирал нь энэхүү дүрэм, компаний засаглалын үндэсний болон улсын шилдэг туршлага, зарчимд нийцүүлэн боловсруулж, ТУЗ-өөс баталсан "Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам"-д заасан зарчмын дагуу дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

6.4.1. Энэ дүрмийн 1.1-д гэрээгээр болон тухай бүр ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, энэ үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл хийх гэрээ байгуулах компанийг төлөөлөх зэргээр компаний нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах

6.4.2. Компаний охин болон хараат компаниудын үйл ажиллагааг удирдан чиглүүлж хяналт тавих ажиллагааг ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх

6.4.3. ТУЗ-ийн хууль ёсны бусад шийдвэрийг хэрэгжүүлэх

6.4.4. Компаний дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг боловсруулан тухайн оны 4 дүгээр улиралд багтаан ТУЗ-өөр батлуулах

6.4.5. Компаний ажилтнуудыг сонгон шалгаруулж, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ болон контракт байгуулан ажиллуулах, ТУЗ-с баталсан цалин урамшууллын хүрээнд ажилтанд цалин урамшуулал олгох.

6.4.6 Компаний гэрээ, контракт, түрээс, тусгай зөвшөөрөл болон эд хөрөнгөд хамаарах өглөг, төлбөр тооцоог хугацаанд нь барагдуулах арга хэмжээ авах.

6.4.7 Компаний нягтлан бодох бүртгэлээр тодорхойлогдсон татвар, хураамжийг цаг хугацаанд нь барагдуулж холбогдох байгууллагатай тооцоо хийх ажлыг зохион байгуулах

6.4.8 Компаний өөрийн үйл ажиллагаа болон хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртэй холбоотой аливаа нэхэмжлэл, шаардлага, мэдэгдлийн талаар ТУЗ-д нэн даруй мэдэгдэх, шаардлагатай арга хэмжээ авах, тайлбар мэдээлэл өгч байх

6.4.9 Их хэмжээний хэлцэлд тооцогдох үнийн дүнтэй маргаан бүхий асуудлаар ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр шүүх, арбитрын ажиллагаанд оролцохгүй байх

6.4.10 Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу санхүүгийн болон бусад тайлан, мэдээ гаргах, эрх бүхий этгээдэд танилцуулах, шаардлагатай тохиолдолд нийтийн хүртээл болгох, хадгалах

6.4.11 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн шийдвэрээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлэн ажиллах бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийн талаар ТУЗ-д улирал бүр мэдээлж байна.

6.5 Энэхүү дүрэмд заасан зүйл заалтыг зөрчиж хийсэн аливаа хэлцэл нь хүчин төгөлдөр бус байх бөгөөд ийнхүү хэлцэл хийсэн нь нотлогдвол гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас чөлөөлж гэрээг цуцална.

## **7. Компаний эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлага**

7.1 ТУЗ нь өөрийн компаний болон хараат охин компаний үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих

7.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн албан тушаалтан:

7.2.1 ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга

7.2.2 Компаний гүйцэтгэх захирал, дэд захирал

7.2.3 Компаний ерөнхий нягтлан бодогч

7.2.4 Газар хэлтэс бусад нэгжийн удирдлага

7.2.5 Компаний зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны цар хүрээнээс хамааруулан ТУЗ-өөс эрх бүхий этгээдээр тооцсон бусад албан тушаалтан байна.

7.3 Компаний эрх бүхий албан тушаалтан нь өөрийн санаатай, шууд буруутай үйл ажиллагаа, хайхрамжгүй байдлаас компанид болон бусдад хохирол учруулсан тохиолдолд хариуцлага хүлээнэ.

### **8. Ажиллах хүч**

8.1 ТУЗ нь компаний зохион байгуулалтын бүтэц болон цалингийн сангийн хэмжээг тусгасан төсвийг батална.

8.2 Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-с баталсан бүтэц, төсвийн хүрээнд ажилтан албан хаагчидтай хөдөлмөрийн болон контракт гэрээ байгуулан ажиллуулна.

8.3 Гүйцэтгэх захирал хөдөлмөрийн харилцаатай холбоотой компаний дотоод журмыг хууль тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлэн батлуулж мөрдүүлнэ.

8.4 Компани нь гэрээ байгуулсан аливаа ажилтанд төлөх цалин хөлснөөс холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, шимтгэлийг заавал суутгаж, нягтлан бодох бүртгэлийн тайланд тусгасан байна.

8.5 ТУЗ-с баталсан төсвөөс давсан санхүүжилт шаардсан өндөр ур чадвар бүхий ажилтан авах, шинээр ажлын байр бий болгох зэрэг асуудлыг гүйцэтгэх захирал ТУЗ-д оруулан шийдвэрлүүлнэ.

### **9. Хөгжлийн санг бүрдүүлэх, зарцуулах**

9.1 Хөгжлийн санг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

9.1.1 Улсын болон аймгийн хөгжлийн сангийн төсвөөс компаний хэрэгжүүлэх тодорхой төслийг санхүүжүүлэхэд зориулан хуваарилсан хөрөнгөөс

9.1.2 Хөрөнгө оруулалтын зээл

9.1.3 Аймгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан гадаад дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний өргөсөн хандив, буцалтгүй тусламжийн орлого

9.1.4 Компаний ашгаас санд оруулсан хөрөнгө

9.1.5 Хөдөө аж ахуй, газар тариалан, уул уурхайгаас олсон орлого

9.1.6 ИТХ-аас тодорхой төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан ашиглахыг зөвшөөрсөн бусад эх үүсвэр

9.1.7 Сангийн түр чөлөөтэй байгаа хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд байршуулснаар авах хүү, ноогдол ашиг, үнийн өсөлтөөс олсон орлого

9.2 Хөгжлийн сангийн хөрөнгийг зөвхөн хөгжлийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан компаний ТУЗ-ийн шийдвэрээр зарцуулна.

9.3 Хөгжлийн сангийн хөрөнгийн хөдөлгөөний тайланг улирал бүр жилийн эхнээс өссөн дүнгээр гаргаж, ТУЗ-ийн гишүүдэд танилцуулна.

## **10.Компаний хөрөнгө**

10.1 Компаний өөрийн хөрөнгө /5 сая төгрөгний эд хөрөнгөтэй бөгөөд нэг бүр нь 100 төгрөг бүхий 50000 мянган ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ/

10.2 Компаний өөрийн хуримтлал ашгаар нэмэгдсэн дүрмийн сан

10.3 Орон нутгийн өмчөөс хууль тогтоомжийн дагуу хуваарилагдан шилжүүлсэн хөрөнгө

10.4 Үйлдвэрлэл үйлчилгээний үр дүнд бий болсон эд хөрөнгө

10.5 Бусад эх үүсвэр

## **11.Компаний санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт**

11.1 Компаний өдөр тутмын үйл ажиллагаанд байнгын хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн ажиллах нь гүйцэтгэх захирлын үүрэг байна. Компаний засаглалын кодексийн зарчимд нийцсэн “Дотоод хяналтын журам”-ыг ТУЗ-ийн хурлаар баталж мөрдүүлнэ.

11.2 Дотоод хяналтын тогтолцоо болон эрсдлийн удирдлага нь зохистой байгаад дүгнэлт өгөх, хяналт тавих зорилгоор ТУЗ-с хяналтын зөвлөлийг байгуулан, түүний үйл ажиллагааны журмыг батлан ажиллуулна.

11.3 Энэхүү зөвлөл нь ТУЗ-с эгсэн шийдвэрийн дагуу төлөвлөгөө удирдамж гарган ажиллаж, эргэж тайлагнана.

11.4 Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж ТУЗ-д танилцуулна. Компаний гүйцэтгэх захирал компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.

11.5 Компани жилийн санхүүгийн тайландаа аудит хийлгэх зорилгоор хяналтын зөвлөл нь нэр хүндтэй аудитын байгууллагыг сонгон гэрээ байгуулж, дүгнэлт гаргуулна.

11.6 Компаний санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусч авар болно.

11.7 Компаний үйл ажиллагаанд аймгийн ИТХ-ын шийдвэрээр томилогдсон эрх бүхий этгээд болон аудитын, татварын болон санхүүгийн байгууллагууд хяналт шалгалт хийх тохиолдолд шаардлагатай баримт материал, ажлын байр, техник хэрэгслээр хангаж ажиллахыг гүйцэтгэх захирал хариуцна.

11.8 Компани нь Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу холбогдох албан татвар, гаалийн татвар, бусад шимтгэл, хуртамж зэргийг төлнө.

11.9 Компаний нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийг төгрөгөөр илэрхийлнэ. Мөнгөн тэмдэгт болон бусад хөрөнгө түүний дотор банкны данс, орлого, зарлага болон өрийг анх хөрөнгө оруулалт хийсэн валютаар бүртгэх ба Монгол банкны албан ёсны ханшийг ашиглан төгрөгт хөрвүүлнэ

## **12. Төсөв тайлан мэдээлэл**

12.1 Компаний гүйцэтгэх удирдлага нь дараах тайлан мэдээллийг гаргаж, тогтоосон хугацаанд эрх бүхий этгээдэд хүргэх, шаардлагатай мэдээллийг нийтийн хүртээл болгох замаар Компаний үйл ажиллагааны нил тод байдлыг хангах үүрэгтэй

12.1.1 Дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон түүнд шаардлагатай хөрөнгийн төсвийг санхүүгийн жил эхлэхээс өмнө гаргаж ТУЗ-д хүргүүлсэн байна.

12.1.2 Тайлант хугацаанд компаний эрх бүхий албан тушаалтад олгосон шагнал урамшуулал, удирдлагын зардлын хэмжээг тайланд тусгана.

12.1.3 Тодорхой төслийг хэрэгжүүлэхээр шалгарсан этгээдийн талаарх танилцуулгыг тухайн этгээдтэй гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор өөрийн цахим хуудсанд тавих замаар нийтэд мэдээлнэ.

## **13. Компанийг татан буулгах**

13.1 Дараах нөхцөл байдал үүссэн буюу үргэлжилж байгаа тохиолдолд аймгийн ИТХ-ын нийт гишүүдийн 2/3-ийн шийдвэрээр компанийг татан буулгана:

13.1.1 Компанид учирсан томоохон алдагдлаас болж үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадваргүй болсон

13.1.2 Хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс болж төлбөрийн чадваргүй болсон ба улмаар компаний хэтийн зорилт бие тэгдэхгүйд хүрсэн

13.2 Хэрэгжүүлж буй төсөл эй холбоотойгоор компани бусдын өмнө хүлээсэн гэрээний үүрэг дуусгавар болоогүй байгаа тохиолдолд компанийг татан буулгах шийдвэр гаргахгүй бөгөөд зайлшгүй татан буулгах ёстой гэж аймгийн ИТХ-ын нийт гишүүдийн 2/3-аас досшгүй хувь нь үзсэн тохиолдолд энэхүү үүргийг хэрэгжүүлэх санхүүгийн бүрэн чадвар бүхий орон нутгийн өмчит аль нэг компанид шилжүүлнэ. Ийнхүү шилжүүлэхтэй холбогдсон асуудлыг төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээний бусад талуудтай хамтран хэлэлцэх бөгөөд тэдгээр нь ийнхүү шилжүүлэхийг зөвшөөрсөн байна. Ингэж чадаагүй тохиолдолд компанийг татан буулгах шийдвэр гаргахыг хориглоно

13.3 Компанийг татан буулгах шийдвэр гаргасан тохиолдолд татан буулгах комиссыг томилж, Компанийг татан буулгах үеийн бүх өрийг төлсний дараа хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлнэ.

13.4 Хуульд заасан үндэслэлээр шүүх компанийг татан буулгах шийдвэр гаргасан бол татан буулгах асуудлыг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

## **14. Үйлчлэх хууль тогтоомж**

14.1 Энэ дүрмийг үйлдэх, түгний хүчин төгөлдөр байдал, хэрэгжүүлэлт, өөрчлөлт болон дуусгавар болгох зэргийг Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулна.

**15. Бусад**

15.1 Энэ дүрэм нь компанийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг байна

15.2 Энэхүү дүрмээр зохицуулдаагүй бусад харилцааг Компаний тухай Монгол Улсын хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 3/3

Номгон

Баянхонгор хотын хөгжлийн ерөнхий  
төлөвлөгөөг буцаах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Солонгос Улсын “Сүсон инженеринг” ХК, Монгол Улсын “Түмэд групп” ХХК-ний гүйцэтгэсэн Баянхонгор хотын ерөнхий төлөвлөгөөг дараах шаардлагыг хангаж, дахин боловсруулалт хийх хүртэл буцаасугай.

- 1.1. Үерийн байгууламжийг төлөвлөх
- 1.2. Хөрсний усны инженерийн систем байгуулах
- 1.3. Морин уралдааны зам төлөвлөх
- 1.4. Гэрлэх ёслолын ордонг төлөвлөх
- 1.5. Дулааны цахилгаан станцыг тодорхой болгох
- 1.6. Чимээгүй хотыг төлөвлөх
- 1.7. Бохирын системийг төлөвлөх /цэвэр, нам, өндөр/
- 1.8. Гамшгийн эрсдлийн үнэлгээ хийлгэх
- 1.9. Цэвэрлэх байгууламжийг шинэчлэх
- 1.10. Түйн гол дамнасан гүүрийг төлөвлөх
- 1.11.Барилгын материалын үйлдвэр, Сүү цагаан идээ боловсруулах үйлдвэрийг төлөвлөх
- 1.12. Цахилгаан эрчим хүчний төлөвлөлтийг сайжруулах

2. Баянхонгор хотыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлтүүдийг хийж 2016 оны 12 дугаар сарын 01-ний дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд дахин хэлэлцүүлэхийг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116020